



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 28

Эрдэнэт

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Инновацийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны Ээлжит XV хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Мэдлэгт суурилсан Эрдэнэт" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.


2. "Мэдлэгт суурилсан Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2016 оны төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

3. Аймгийн Засаг дарга С. Дангаасүрэнд ДААЛГАХ нь:

3.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч биелэлтийг 2016 оны XII сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнах.

3.2. Энэ чиглэлээр гарсан Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлтийн явцыг нэгтгэн тооцож, дүнг дээрх төлөвлөгөөний биелэлттэй хамтатган танилцуулах.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН